БАТЛАВ.
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.АМАРТӨГС
2024 оны 03 сарын 27 өдөр

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙН ХАШААНЫ ТОХИЖИЛТЫН ЖИШИГ ЗУРАГ, ТӨСӨЛ, ЖИЖИГ ГЭР ХОРООЛЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024.03.27 Дугаар ЗТ-1403/2024 Даланзадгад

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; Өмнөговь аймгийг 2024 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө
2	Барилга байгууламжийн байршил:	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын дэвсгэрт
3	Захиалагч байгууллага:	Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар
4	Архитектур төлөвлөлтийн объектын бүрэлдэхүүн шаардлага, хүчин чадал:	Даланзадгад сумын нэг хорооллыг сонгон жижиг гэр хороолол болон жишиг хашааны тохижилтын зураг төсөв боловсруулах. Жижиг хорооллын зураг: Хорооллыг сонгосны дараа захиалагчаас нэмэлт санал авах. 1. Ногоон байгууламж /зүлэг, бут, сөөг, мод/ 2. Хүүхдийн тоглоомын талбай / Жишиг хороололд төлөвлөх/ 3. Сагсны талбай 4. Чийрэгжүүлэх талбай 5. Гоёлын хашаа хайс 6. Явган хүний зам 7. Гоёлын гэрэлтүүлэг 8. Сандал, сүүдрэвч, хогийн сав Жишиг хашааны тохижилт: 0,07га талбайд төлөвлөнө. 1. Гадна хашааны зураг /Орчин цагийн хийцлэлтэй / 2. Хашааны дотор ногоон байгууламж /Говийн нөхцөлд тарьж ургуулах боломжтой байхаар сонгоно/ 3. Гадна гэрэлтүүлэг / хашааны орон зай, явган замд тааруулан нарны толин явган гэрэл төлөвлөх/ 4. Хашаанд бохирын цооног болон бохир усны худаг байрлах хэсгийг барилга байгууламжаас 10м-с багагүй зайд төлөвлөнө 5. Хашаанд гаднаас нь хог хаягдлыг ачих боломж бүхий дотороос нь хогийг ангилан хаях хогийн цэгийг төлөвлөнө 6. Хашааны төлөвлөлтөд / Зуны хүлэмж, Агуулах, Тоглоомын талбай, Сүүдрэвч/ аль нэгийг нь сонгон хийх талбайн хэсгийг тусгана 7. Авто машины орох, гарах хөдөлгөөн нь явган хүний орох, гарах хөдөлгөөнд саад болохооргүй параллель байхаар төлөвлөнө
5	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	Орчны зам талбай, барилга байгууламжтай уялдуулан төлөвлөх, явган хүний урсгалыг оновчтой сонгох, цахилгааны эх үүсвэрийг тодорхойлох
6	Ерөнхий төлөвлөгөө,	Норм, нормативууд

	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	• Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм /БНбД 30-01-04/ • Олон нийтийн барилгын норм дүрэм /БНбД 31.03.03/ • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч, зам, налуу шатыг шийдэх /MNS 6056.2003, 6055:2009/ • Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм Бусад холбогдох норм, дүрэм
7	Технологийн шийдэл:	Гадна тохижилтын тоноглолуудыг гоёлын шийдлээр сонгох, гэрэлтүүлгийг орчин үеийн хүчин чадал сайтай лед, өнгө үзэмж сайтай гоёлын байхаар төлөвлөх.
8	Гүйцэтгэх ажлууд:	Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсны дараа тухайн барилга байгууламжийн захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөж нэмэлт санал авна. Зураг төсөл боловсруулах бэлтгэл ажил буюу зураг төслийн бүрдэл нь дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд: - Барилга Архитектур - /БА/ - Ерөнхий төлөвлөгөө - /ЕТ/ - Цахилгаан хангамж - /ЦХ/ - Холбоо дохиолол - /ХД/ - Хүчит төхөөрөмж - /ХТ/ - Гадна шугам сүлжээ - /ГШС/ - Геодезийн хэмжилтийн тайлан - Инженер геологийн дүгнэлт - Төсөв - Ажлын тоо хэмжээн жагсаалт Иж бүрэн батлагдсан зураг, төсөв хүлээн авна. - Хэвлэмэл байдлаар 3 хувь - CD байдлаар 3 хувь захиалагчид хүлээлгэн өгнө. - Ажлын зураг, төсвийг эх хувиас нь сканердан pdf форматаар 300 dpi нягтралтай cd-нд хавсаргах - Ерөнхий төлөвлөгөөг dwg форматаар cd-нд хавсаргах
9	Барилга байгууламжийн үндсэн бүтээц, хийцийн шийдэл:	1. Ногоон байгууламж – орон нутгийн онцлог, хөрсөнд тохирсон ургамал 2. Гоёлын хашаа хайс – Төмөр, тоосго, чулуу, мод 3. Явган хүний зам – Явган замын өнгөт хавтан, боржин чулуу 4. Гоёлын гэрэлтүүлэг – Төмөр, никель 5. Хогийн цэг – Төмөр, хуванцар
10	Инженерийн хангамжийн эх үүсвэр:	Гадна инженерийн шугам сүлжээний хангамжийг олгогдсон техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох
11	Зураг төслийн үе шат, хугацаа:	Зураг төсөл боловсруулах 1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаанд
12	Хөрөнгийн эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
13	Зураг төсөл гүйцэтгэгч байгууллага	Тендерт оролцогч эрх бүхий байгууллага нь эскиз зураг төслөөр өрсөлдөх ба хамгийн сайн үнэлэгдсэн зургийг шалгаруулна.
14	Зураг төсвийн үнэ:	Зураг төсвийн жишиг үнэ: БД81-16-12*2020
15	Онцгой нөхцөл:	▪ Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНбД 22-01-01-ийн 2.5-ын 4-р хүснэгтийн 5-д заасан

		үндэслэлээр газар хөдлөлтийг тооцох. ▪ Галд шатдаг материал үндсэн хийцэд ашиглахгүй байх

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Ц.ЗОЛБОО

ОМНОГОВЬ АЙМГИЙН
ЕРӨНХИЙ
АРХИТЕКТОР
ЕА 15